

**АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	21
5.1 Төлбөрийн акт .....	21
5.2 Албан шаардлага .....	23
5.3 Зөвлөмж.....	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	25

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын их хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМД	Эрүүл мэндийн даатгал



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Н.ЦЭРЭНСОДНОМ ТАНАА

2026.03.16 № 735  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,905.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал,

- Санхүүгийн тайланд 18 санхүүгийн түрээсийн үндсэн болон хүү, алдангийн төлбөрийн 40,995.8 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 5 түрээсийн 16,878.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Тайлант онд 12.5 сая төгрөгийн бараа материал худалдан авсныг шууд зардалд бүртгэсэн, ашиглалтад байгаа хангамжийн материалыг бараа материалын зардалд тусгасан, мөн бараа материалын тайланг нэр төрлөөр бэлтгээгүй, жилийн эцэст тооллого хийгээгүй;
- Компанийн нэр бүхий 2 ажилтанд гадаад албан томилолтоор БНСУ-д ажиллахад "Бусад зардал" нэрээр тус бүр 1000 ам.доллар төсөвлөж, 6.9 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан;
- Монгол Улсын Хөгжлийн банктай 9 удаагийн 661.0 сая ам.долларын бодит бус форвард хэлцэл байгуулж, хэлцлийн ханшийн зөрүүнээс өр төлбөр үүсээгүй ч нягтлан бодох бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланд толилуулж, тодруулаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 70 дугаар зүйлийн 70.2, Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандарт 9 санхүүгийн хэрэгсэл стандартын 5.1.1, 5.1.7, 13-ын 9, НББОУС 32-т заасантай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн ба зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд шүүхийн шийдвэрийн дагуу Хаан шоргоолж ХХК-аас 5,086.5 сая төгрөг, Алтайн хязгаар ХХК-аас 1,746.9 сая төгрөг, нийт 6,833.4 сая төгрөгийн түрээсийн үндсэн төлбөр, хүү, алдангийн авлага хүчингүй болсон байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн түрээсийн багцын чанар муудаж, нийт 64,236.3 сая төгрөгийн санхүүгийн түрээсийн үлдэгдлийн 71.8 хувь буюу 7 санхүүгийн түрээсийн үнэ цэнэ буурч 181-ээс дээш хоног хугацаа хэтэрч эргэлзээтэй, муу ангилалд бүртгэгдсэн байна. Зарим санхүүгийн түрээсийн гэрээнд 73–100 хувийн эрсдэлийн сан байгуулсан нь тухайн түрээсийн санхүүжилт эргэн төлөгдөх боломж эрс буурсныг харуулж, компанийн ашигт ажиллагааг бууруулах үр дагавартай байна.

Ди Би Эм лизинг ХХК-ийн засаглалын үнэлгээ 63.9 хувь буюу "хангалтгүй" үнэлэгдсэн нь "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг зохицуулаагүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх зарим байнгын болон түр хороог байгуулаагүй, компанийн бүтцийг шинэчлэн батлахдаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргын албан үүргийг дотоод аудиторт хавсран хариуцуулсан нь дотоод аудитын хараат бус байдлыг алдагдуулж, улмаар хяналтын үр нөлөө буурах эрсдэл үүсгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн аудитын байгууллага нь АДБОУС-ын дагуу аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,848,064,719.71	687,854,784.00
1.1.2	Дансны авлага	28,780,259,413.74	23,207,557,807.58
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	217,516.36
1.1.4	Бусад авлага	113,999.98	3,743,375.50
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	64,045,531,012.55	84,614,221,257.51
1.1.6	Бараа материал	169,479.56	1,799,949.56
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	0.46
<b>1.1.8</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>94,674,138,625.54</b>	<b>108,515,394,690.97</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,294,810,712.32	1,244,521,018.31
1.2.2	Биет бус хөрөнгө	3,731,821.74	2,811,821.71
1.2.3	Санхүүгийн түрээсийн авлага	27,725,287,690.48	20,203,393,419.35
<b>1.2.4</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>29,023,830,224.54</b>	<b>21,450,726,259.37</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>123,697,968,850.08</b>	<b>129,966,120,950.34</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	160,096,038.28	59,750,238.49
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	828,485,173.78	306,353,003.70
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
<b>2.1.1.12</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>988,581,212.06</b>	<b>366,103,242.19</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>988,581,212.06</b>	<b>366,103,242.19</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	100,000,000,000.00	100,000,000,000.00
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.3	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.5	Хуримтлагдсан ашиг	19,056,650,913.79	22,726,162,638.02
2.3.6	Тухайн жилийн ашиг	3,652,736,724.23	6,873,855,070.13
<b>2.3.7</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>122,709,387,638.02</b>	<b>129,600,017,708.15</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>123,697,968,850.08</b>	<b>129,966,120,950.34</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31-ний дүн	2025 оны 12 дугаар сарын 31-ний дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,950,000,793.61	4,000,035,135.36
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	4,950,000,793.61	4,000,035,135.36
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	4,739,416,022.79	9,569,774,717.44
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	1,571,220,177.13	900,893,880.48
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,724,707,905.80	1,764,193,599.58
11	Санхүүгийн зардал	4,325,324,439.48	-
12	Бусад зардал	601,619,137.38	4,925,807,365.34
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(53,525,522.22)	8,499,045.32
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	341,989,560.11
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,555,459,988.65	8,131,191,373.79
19	Орлогын татварын зардал	902,723,264.42	1,257,336,303.66
20	Татварын дараах ашиг (алдагдал)	3,652,736,724.23	6,873,855,070.13
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	3,652,736,724.23	6,873,855,070.13
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	3,652,736,724.23	6,873,855,070.13
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000,000.00	19,056,650,913.79	119,056,650,913.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-
3	Залруулсан үлдэгдэл	100,000,000,000.00	19,056,650,913.79	119,056,650,913.79
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		3,652,736,724.23	3,652,736,724.23
5	Бусад дэлгэрэнгүй орлого			
6	Өмчид гарсан өөрчлөлт			
7	Зарласан ногдол ашиг			
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
9	2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	100,000,000,000.00	22,709,387,638.02	122,709,387,638.02
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		16,775,000.00	16,775,000.00
11	Залруулсан үлдэгдэл	100,000,000,000.00	22,726,162,638.02	122,726,162,638.02
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		6,873,855,070.13	6,873,855,070.13
13	Бусад дэлгэрэнгүй орлого			
14	Өмчид гарсан өөрчлөлт			
15	Зарласан ногдол ашиг			
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
17	2025 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	100,000,000,000.00	29,600,017,708.15	129,600,017,708.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 дугаар сарын 31-ний дүн	2025 оны 12 дугаар сарын 31-ний дүн
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>43,320,635,083.00</b>	<b>3,834,669,184.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	980,406,540.00	3,570,646,243.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Бусад мөнгөн орлого	42,340,228,543.00	264,022,941.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,633,451,288.97</b>	<b>2,852,909,539.99</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	862,533,791.00	1,031,699,627.11
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	242,979,324.00	294,446,373.85
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	14,207,051.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	3,605,617.00	12,808,986.03
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	879,876,866.00	1,265,133,251.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	17,547,750.00	7,395,150.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	626,907,940.97	227,219,101.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>40,687,183,794.03</b>	<b>981,759,644.01</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>55,260,006,911.00</b>	<b>85,097,538,629.00</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	31,000,000,000.00	63,000,000,000.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	22,327,635,222.00	13,140,585,829.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,932,371,689.00	8,956,952,800.00
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>123,568,638,769.00</b>	<b>87,239,508,208.72</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	48,782,384.00	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	120,236,905,355.00	84,000,000,000.00
2.2.4	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	3,282,951,030.00	3,239,508,208.72
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(68,308,631,858.00)</b>	<b>(2,141,969,579.72)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
4	Валютын ханшийн зөрүү	(2,729,758.00)	-
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(27,624,177,821.97)</b>	<b>(1,160,209,935.71)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>29,472,242,541.68</b>	<b>1,848,064,719.71</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,848,064,719.71</b>	<b>687,854,784.00</b>

**2.5 Бизнес төлөвлөгөөний 2025 оны гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Санхүүгийн тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Актив</b>	<b>168,771.4</b>	<b>129,916.3</b>	<b>38,855.1</b>	<b>77.0</b>
1.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	32,998.0	85,302.1	(52,304.1)	258.5
1.2	Санхүүгийн түрээс	118,359.0	20,203.4	98,155.6	17.1
1.3	-Түрээсийн багц	141,135.4	40,995.8	100,139.6	29.0
1.4	-Эрсдэлийн сан	(22,776.4)	(20,792.4)	(1,984.0)	91.3
1.5	Санхүүгийн түрээсийн бусад авлага	16,164.0	23,160.6	(6,996.6)	143.3
1.6	Дериватив санхүүгийн хөрөнгө	-	-		
1.7	Үндсэн хөрөнгө	1,249.8	1,217.4	32.4	97.4
1.8	Бусад хөрөнгө	0.6	32.8	( 32.2)	5466.7
<b>2</b>	<b>Пассив</b>	<b>42,467.2</b>	<b>348.5</b>	<b>42,118.7</b>	<b>0.8</b>
2.1	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	41,575.0	-	41,575.0	0.0
2.2	Бусад өр төлбөр	892.2	348.5	543.7	39.1
<b>3</b>	<b>Өөрийн хөрөнгө</b>	<b>126,304.8</b>	<b>129,555.3</b>	<b>(3,250.5)</b>	<b>102.6</b>
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	100,000.0	100,000.0	-	100.0
3.2	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	26,304.8	29,555.3	(3,250.5)	112.4
3.3	Бусад өөрийн хөрөнгө	-	-		
<b>4</b>	<b>Нийт пассив ба өөрийн хөрөнгө</b>	<b>168,772.0</b>	<b>129,903.9</b>	<b>38,868.1</b>	<b>77.0</b>
№	Орлогын тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Хүүгийн орлого	11,989.3	14,458.3	(2,469.0)	120.6
1.1	-Түрээс	8,774.8	3,987.6	4,787.2	45.4
1.2	-Хадгаламж	3,214.5	10,470.7	(7,256.2)	325.7
1.3	Хүүгийн зардал	(2,853.0)	-	(2,853.0)	-
<b>2</b>	<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>9,136.3</b>	<b>14,458.3</b>	<b>(5,322.0)</b>	<b>158.3</b>
2.1	Үнэ цэнийн бууралтын (зардал)/буцаалт	(316.9)	2,249.6	(2,566.5)	709.9
<b>3</b>	<b>Үнэ цэнийн бууралтын дараах хүүгийн цэвэр орлого/(зардал)</b>	<b>8,819.4</b>	<b>16,707.9</b>	<b>(7,888.5)</b>	<b>189.4</b>
3.1	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн ашиг/(алдагдал)	(124.7)	8.5	(133.2)	6.8
3.2	Шимтгэл, хураамжийн орлого/(зардал)	-	-		
3.3	Үйл ажиллагаатай холбоотой зардал	(2,416.5)	(1,896.5)	(520.0)	78.5
3.4	Бусад олз/(гарз)	(2,081.2)	(6,833.4)	(4,752.2)	328.3
<b>4</b>	<b>Татварын өмнөх ашиг/(алдагдал)</b>	<b>4,197.0</b>	<b>7,986.5</b>	<b>(3,789.5)</b>	<b>190.3</b>
4.1	Орлогын албан татварын (зардал)/буцаалт	(419.7)	(1,140.5)	720.8	271.7
4.2	Татварын дараах ашиг/(алдагдал)	3,777.3	6,846.0	(3,068.7)	181.2

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Ди Би Эм лизинг ХХК нь УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоол, Засгийн газрын 2015 оны 407 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани хэлбэрээр 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр дунд болон урт хугацаатай санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх замаар үйлдвэржилтийг дэмжих, урт хугацаатай, өртөг багатай тоног төхөөрөмжийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, улмаар олон салбарыг тогтвортой хөгжүүлэх санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх үндсэн зорилготойгоор үүсгэн байгуулагдсан байна.

Дээрх зорилгын хүрээнд уул уурхай, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам тээвэр, боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүнд даацын машин, механизм, техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад санхүүгийн түрээсийн үйлчилгээг үзүүлж байна. УИХ-аас баталсан 2021 оны 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан төсөл хөтөлбөрүүдэд санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Ди Би Эм лизинг ХХК нь эрхэм зорилгоо “Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрүүд болон импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай техник, тоног, төхөөрөмжөөр санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэхэд оршино” гэж тодорхойлсон бөгөөд дараах стратегийн зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

Стратегийн зорилт 1. Олон улсын банк, санхүүгийн байгууллага, үйлдвэрлэгч болон борлуулагч компаниудтай тогтвортой, олон талт хамтын ажиллагааг өрнүүлэх, урт хугацаатай хямд өртөгтэй санхүүгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх;

Стратегийн зорилт 2. Лизингийн сонгодог зах зээлийг хөгжүүлж, зах зээлд оновчтой бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар тогтвортой хөгжлийг бий болгох;

Стратегийн зорилт 3. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, үр ашигтай явуулах нөхцөлийг хангах, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль, эрх зүй, захиргааны болон хүний нөөцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, компанийн үндсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Ди Би Эм лизинг ХХК нь үйл ажиллагаандаа дараах эрх зүйн актыг мөрдөж ажилладаг байна. Үүнд:

- *Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;*
- *Иргэний хууль;*
- *Компанийн тухай хууль;*
- *Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль;*
- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;*
- *Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хууль;*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;*
- *Төрийн хэмнэлтийн тухай хууль;*
- *Хөдөлмөрийн тухай хууль;*
- *Шилэн дансны тухай хууль.*

Тайлант хугацаанд Ди Би Эм лизинг ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлд гүйцэтгэх удирдлага (гүйцэтгэх захирал) нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гэрээ хэлцэл байгуулах, компанийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг гаргах бүрэн эрхийн талаар заасан бол тус хуулийн 62 дугаар зүйлд Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн стратеги, бодлого, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Компанийн Санхүүгийн түрээсийн бодлогын 6.3 дахь заалтад санхүүгийн түрээсийн судалгаа, шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар заавал хэлэлцүүлж шийдвэрлэхээр зохицуулсан нь гүйцэтгэх удирдлагын хуулиар олгогдсон бүрэн эрхийг хязгаарлаж, түргэн шуурхай шийдвэр гаргах боломжийг бууруулж байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тайлант онд Монгол Улсын Хөгжлийн банкны Дотоод аудитын газраас Ди Би Эм лизинг ХХК-ийн 2024 он, 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 02/31 дүгээр тогтоолоор “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн баталсан байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой хууль, журам, бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,268.1 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,848,064.7	687,854.8	(1,160,209.9)
Авлага	28,780,373.4	23,211,518.7	(5,568,854.7)
Бусад санхүүгийн хөрөнгө	64,045,531.0	84,614,221.3	20,568,690.2
Бараа материал	169.5	1,799.9	1,630.4
Үндсэн хөрөнгө	1,294,810.7	1,244,521.0	(50,289.7)
Биет бус хөрөнгө	3,731.8	2,811.8	(920.0)
Санхүүгийн түрээсийн авлага	27,725,287.7	20,203,393.4	(7,521,894.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>123,697,968.8</b>	<b>129,966,120.9</b>	<b>6,268,152.1</b>
Өр төлбөр	988,581.2	366,103.2	(622,478.0)
Эздийн өмч	122,709,387.6	129,600,017.7	6,890,630.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>123,697,968.8</b>	<b>129,966,120.9</b>	<b>6,268,152.1</b>

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, авлага, бусад санхүүгийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, санхүүгийн түрээсийн авлага өр төлбөр, эздийн өмчийн данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Тухайлбал,

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 687.8 сая төгрөг болж, 1,160.2 сая төгрөгөөр буурсан нь арилжааны банканд хугацаатай хадгаламж байршуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 23,211.5 сая төгрөг болж, 5,568.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-иас авах авлага төлөгдсөнтэй холбоотойгоор буурсан байна.

Бусад санхүүгийн хөрөнгө дансны үлдэгдэл 84,614.2 сая төгрөг болж, 20,568.7 сая төгрөгөөр өссөн нь санхүүгийн түрээсийн эргэн төлөлт болон авлага барагдсантай холбоотойгоор мөнгө хөрөнгө өсөж, чөлөөт мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах замаар 3 сараас дээш хугацаатай хадгаламжийн дансанд байршуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,244.5 сая төгрөг болж, 50.3 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд үүний үр дүнд үндсэн хөрөнгийн цэвэр дүн буурсан байна.

Санхүүгийн түрээсийн авлага дансны үлдэгдэл 20,203.4 сая төгрөг болж, 7,521.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд санхүүгийн түрээсийн авлага 6,770.3 сая төгрөг, хуримтлагдсан хүү болон торгуулийн хүүгийн авлага 2,384.9 сая төгрөг, үнэ цэнийн бууралтын алдагдлын сан (1,633.3) сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 366.1 сая төгрөг болж, 622.5 сая төгрөгөөр буурсан нь татварын өр төлбөрийг төлж барагдуулсантай холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 129,600.0 сая төгрөг болж, 6,890.6 сая төгрөгөөр өссөн нь компани тайлант онд 6,890.6 сая төгрөгийн ашигтай ажиллаж хуримтлагдсан ашиг өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Ди Би Эм лизинг ХХК-ийн дүрмийн 15.1.2<sup>1</sup>, 16.6.7<sup>2</sup>-д заасны дагуу компанийн стратегийн зорилт, урт, дунд хугацааны болон тухайн жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

#### Бизнес төлөвлөгөөний үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөнд санхүүгийн түрээс олголтыг 103,900.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 3,200.0 сая төгрөг, санхүүгийн түрээсийн эргэн төлөлтийг 23,319.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 23,859.0 сая төгрөг болж зорилтот түвшиндээ хүрээгүй ч ашиг 3,889.0 сая төгрөг байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6,846.0 сая төгрөгт хүрсэн байна.

#### Хүснэгт 2. Түрээс, тусгай активын үйл ажиллагааны хэмжих үзүүлэлт

			/сая төгрөгөөр/	
№	Зээл, тусгай активын үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Санхүүгийн түрээс олголт	103,900.0	3,200.0	
2	Санхүүгийн түрээсийн эргэн төлөлт	29,319.0	23,859.0	
3	Тусгай активд шилжсэн санхүүгийн түрээсийн эргэн төлөлтийн дүн	8,000.0	850.0	
4	Ашигт ажиллагаа	3,889.0	6,846.0	

Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөнд татан төвлөрүүлэх зорилтот эх үүсвэрийн хэмжээг 41,200.0 сая төгрөгт хүргэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр хөрөнгө татан төвлөрүүлээгүй байна.

#### Хүснэгт 3. Эх үүсвэрийн үйл ажиллагааны хэмжих үзүүлэлт

/сая төгрөгөөр/

<sup>1</sup> 15.1.2 Компанийн стратеги зорилтуудыг тодорхойлж, урт, дунд хугацааны болон тухайн жилийн бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах,

<sup>2</sup> 16.6.7 Компанийн стратегийн зорилт, урт, дунд хугацааны болон тухайн жилийн бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж, шийдвэрлүүлэх, түүний хэрэгжилтийг зохион байгуулах,

№	Хөрөнгийн удирдлагатай холбоотой үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Татан төвлөрүүлэх зорилтот эх үүсвэрийн хэмжээ	41,200	-

Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөнд санхүүгийн түрээст эзлэх хэвийн зээлийн хэмжээг 84.1 хувьд хүргэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэл 42.9 хувьтай, нийт санхүүгийн түрээст эзлэх чанаргүй зээлийн хэмжээг 9.3 хувьтай байхаар төлөвлөсөн байхад гүйцэтгэл 57.1 хувьтай байгаа бол харин өөрийн хөрөнгийн хүрэлцээ, өгөөж төлөвлөснөөс давсан үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 4. Санхүүгийн харьцааны хэмжих үзүүлэлт*

№	Түлхүүр үнэлгээний үзүүлэлт	Төлөвлөгөө /хувиар/	Гүйцэтгэл /хувиар/
1	Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ	93.0	236.5
2	Нийт санхүүгийн түрээст эзлэх хэвийн зээл	84.1	42.9
3	Нийт санхүүгийн түрээст эзлэх чанаргүй зээл	9.3	57.1
4	Өөрийн хөрөнгийн өгөөж	3.4	5.3

Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгааны үр дүнгийн талаар: Үүнд

*1. Компанийн орон тооны цомхотголын талаар*

ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 12 дугаар тогтоолоор бүтэц, орон тоог 16 ажилтнаар, 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 13 дугаар тогтоолоор бүтэц орон тоог 19 ажилтнаар тус тус баталсан байна.

*2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:*

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, Ди Би Эм лизинг ХХК-ийн дүрмийн 16.6.2, 16.6.6 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 8.2, Цалин хөлсний журмын 5.3.1-т тус тус заасныг үндэслэн нэг өдрийн унааны хөнгөлөлтийг 1,000.00 төгрөг, хоолны хөнгөлөлтийг 11,900.00 төгрөгөөр баталж, тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтөд 73.8 сая төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр 49.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

*3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:*

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 18.0 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 14.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

*4. Гадаад томилолтын судалгааны үр дүн:*

Тайлант онд 5 чиглэлд хамтын ажиллагааг эхлүүлэх, мэдлэг, туршлагаа хуваалцах зорилгоор 6 албан хаагч гадаад албан томилолтоор ажиллаж нийт 43.9 сая төгрөг зарцуулсан байна.

*5. Хэвлэл мэдээллийн судалгааны үр дүн:*

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллага, үйл ажиллагаагаа сурталчлах болон цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх зорилготой зардал гараагүй байна.

*6. Программ хангамжийн судалгааны үр дүн:*

Тус компани нь үйл ажиллагаандаа 26.4 сая төгрөгийн өртөг бүхий программуудыг ашигладаг, тайлант онд компьютерын хэрэглээний программ болон вирусийн хамгаалалтын программын жилийн үйлчилгээний хураамжид 7.7 сая төгрөг төлсөн байна.

7. Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал тус тус гараагүй байна.

**Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:**

“Ди Би Эм Лизинг” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/38 дугаар тушаалаар компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Нийт 265.3 сая төгрөгийн 21 бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн ба 19 бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авахаар, 100.0 сая төгрөгийн 1

ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 29.9 сая төгрөгийн барааг ерөнхий гэрээний аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 195.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээ авах 100.0 сая төгрөгийн нээлттэй тендерийг Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүгийн тайланд аудит хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн хамт зарлаж, гэрээг байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн нягтлан бодох бүртгэл болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Зэндмэнэ, М.Доржханд, Б.Буянхишиг, ахлах аудитор Ч.Ариунаа, аудитын менежер Б.Золбаяр, Б.Өлзий, П.Ундармаа, И.Туяадарь нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер, аудитын багийн ахлагч Б.Саруул, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Ди Би Эм лизинг ХХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03/28/26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг компанийн 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 9,720.0 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 145.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Компанийн цахим хуудсанд ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлын ажлын байранд тавигдах шаардлага, Гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, компанийн 2025 онд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, ЭМДШ, НДШ-ийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21№ дүгээр зүйлийн 13-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна”, “20.3-т “Энэ хуулийн 15.4-т заасан гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна”, 20.4-т “Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн

этгээдэд ногдуулсан аливаа акт, албан шаардлага, зөрчлийн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна” гэсэнтэй тус тус нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Байгууллагын цахим хуудсанд ил тод мэдээлэх мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Илрүүлэлт:* Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 119 гүйлгээнээс 3,643.9 сая төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож, 19,737.0 сая төгрөгийн 111 мэдээллийг мэдээлээгүй, зарлагын нийт 14 гүйлгээнээс 42.8 сая төгрөгийн 5 мэдээллийг мэдээлээгүй, 212.7 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг ил тодоор мэдээлэх нийт 219.5 сая төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй, мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 3 шийдвэрийг нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-т “5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

*Илрүүлэлт 1:* Ди Би Эм лизинг ХХК-ийн засаглалын үнэлгээ 63.9 хувь буюу “хангалтгүй” үнэлэгдсэн нь “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг зохицуулалгүй орхисон, ТУЗ-ийн дэргэдэх зарим байнгын болон түр хороог байгуулаагүй, компанийн бүтцийг шинэчлэн батлахдаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргын албан үүргийг дотоод аудиторт хавсран хариуцуулсан нь дотоод аудитын хараат бус байдлыг алдагдуулж, улмаар хяналтын үр нөлөө буурах эрсдэл үүсгэсэн байна. ТУЗ-өөс компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналтай холбоотой бодлого, журмыг батлаагүй, мэдээллийг олон нийтэд тогтмол түгээх дотоод зохицуулалт болон хариуцсан нэгжийн үүрэг тодорхойгүй, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавиагүй, ТУЗ-ийн дарга, гишүүд болон нарийн бичгийн даргын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг жилд нэг удаа тогтмол хугацаанд хийж, тайлагнах үүргээ биелүүлээгүй, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарт харьяалагдах байгууллагуудыг комплайнсын хяналтын бүтэц, заавартай байж, комплайнсын хяналтыг заавал хэрэгжүүлэхийг шаарддаг ч комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажилтныг томилоогүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг тодорхой болгох, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын албан үүргийг дотоод

аудитор хавсран гүйцэтгүүлэхгүй байх, компанийн засаглалын 9 зарчмыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт 2:** Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөнд санхүүгийн түрээст эзлэх хэвийн зээлийн хэмжээг 2025 онд 84.1 хувьд хүргэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэл 42.9 хувьтай, 41.2 нэгжээр бага, нийт санхүүгийн түрээст эзлэх чанаргүй зээлийн хэмжээг 9.3 хувьтай байхаар төлөвлөсөн байхад гүйцэтгэл 57.1 хувьтай байгаа зэргээр санхүүгийн түрээсийн багцын чанар муудаж, зээлийн эргэн төлөлтийн эрсдэл нэмэгдсэн байна.

Энэ нь байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж, үйл ажиллагааны цар хүрээ хумигдах үр дагавартай байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх, 84.4.3-т компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн түрээсийн багцын чанар төлөвлөсөн түвшинд хүрээгүй шалтгаан, нөхцөлийг иж бүрэн үнэлж, хэвийн зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанаргүй зээлийг бууруулах, эргэн төлөлтийг сайжруулах чиглэлээр санхүүгийн түрээсийн багцын удирдлага, зээлийн шалгуур, эрсдэлийн хяналтын тогтолцоог дахин сайжруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт 3:** Компани нь 2025 онд үндсэн үйл ажиллагаа болох санхүүгийн түрээсийн шинэ зээл санхүүжүүлээгүй, хүүгийн орлого олох боломжийг эрэлхийлж ажиллаагүй, мөнгөн хөрөнгийг арилжааны банкны хадгаламжид байршуулах замаар үйл ажиллагаа явуулж байгаа нь компанийг байгуулсан зорилго зорилттой нийцэхгүй байгаа нь санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай төсөл, хөтөлбөр хэрэгжихгүй байх үр дагавартай байна.

**Шийдвэрлэсэн нь:** Компанийн үндсэн үйл ажиллагаа болох санхүүгийн түрээсийн санхүүжилтийг сэргээх, хүүгийн орлого бүрдүүлэх үндсэн чиг үүргийг идэвхжүүлэх, мөнгөн хөрөнгийг хадгаламжид төвлөрүүлэх байдлаар ашиглах явдлыг зогсоож, компанийн зорилго, зорилтод нийцсэн ашигт ажиллагааг ханган ажиллах зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт 4:** Санхүүгийн түрээсийн багцын чанар муудаж, нийт 64,236.3 сая төгрөгийн санхүүгийн түрээсийн /ХААК ХХК-ийн авлагыг оруулсан дүнгээр/ үлдэгдлийн 71.8 хувь буюу 46,127.6 сая төгрөгийн 7 санхүүгийн түрээсийн үнэ цэнэ буурч 181-ээс дээш хоног хугацаа хэтэрч эргэлзээтэй, муу ангилалд бүртгэгдсэн. Зарим санхүүгийн түрээсийн гэрээнүүдэд 73–100 хувийн эрсдэлийн сан байгуулсан нь тухайн түрээсийн санхүүжилт эргэн төлөгдөх боломж эрс буурсныг харуулж, компанийн ашигт ажиллагааг бууруулах үр дагавартай байна. Энэ нь Ди Би Эм лизинг ХХК-ийн дүрмийн 7.1.2-т Үндэсний үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэх болон үр ашигтай ажиллах зарчмын тэнцвэрт байдлыг хангах гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн түрээсийн чанаргүй багцад иж бүрэн үнэлгээ хийж, эргэн төлөлт барагдуулах, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг санхүүгийн түрээс тус бүрээр тус бүрээр тодорхойлон хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт 5:** Тайлант оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эрсдэлийн сан байгуулсан тооцооллоор 12 санхүүгийн түрээст "0" хувиар эрсдэлийн санг байгуулсан байна. ТУЗ-ийн 2025 оны 15 дугаар тогтоолоор баталсан "Актив ангилах, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын 3.7-д зааснаар шатлал 2, шатлал 3 ангилалд орсон зээлийг тус журмын Хавсралт 1-д заасан "Эрсдэлийн сан тооцох аргачлал"-аар тооцоолохоор заасан харин шатлал 1-д байх зээлд эрсдэлийн сан байгуулах заалт байхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** "Актив ангилах, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдээгүй буюу шатлал 1-д ангилсан зээлүүдэд 12 сарын хугацаанд үүсэх магадлалтай зээлийн алдагдлыг тооцож, түүнд үндэслэн эрсдэлийн сан байгуулах, СТОУС 9 /Санхүүгийн хэрэгсэл/-ийн 5.5.3, 5.5.5, 5.5.9, 5.5.17-ыг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт 6:** Ди Би Эм лизинг ХХК нь 2025 онд Монгол Улсын Хөгжлийн банкттай 9 удаагийн 661.0 сая ам.долларын бодит бус форвард хэлцэл байгуулж, хэрэгжүүлснийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланд толилуулаагүй байна.

Энэ нь СТОУС 9 /Санхүүгийн хэрэгсэл/-ийн 5.1.1, 5.1.7, СТОУС 13 /Бодит үнэ цэнийн хэмжилт/-ын 9, НББОУС 32-ыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бодит бус форвард хэлцэл байгуулж, хэрэгжүүлснийг стандартын дагуу нягтлан бодох бүртгэлд бүртгэх зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт 7:** Нийт 25,547.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй 6 санхүүгийн түрээсийн зүйлээс хүний нөөцийн дутагдалтай, түрээслэгч үнэлгээ хийлгэхээс татгалзсан зэрэг шалтгааны улмаас 3 түрээсийн зүйлд үнэлгээ хийгдээгүй байна.

Энэ нь тус компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/11 дүгээр тушаалаар баталсан "Барьцаа хөрөнгийн үнэлгээний журам"-ын 5.2-т "Барьцаа хөрөнгийг жил бүр үнэлэх" заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** "Барьцаа хөрөнгийн үнэлгээний журам"-ын дагуу түрээсийн зүйлийг үнэлэх, барьцаа хөрөнгийн үнэлгээг үнэлгээ хийх зөвшөөрөлтэй ажилтан, хувь хүн, хуулийн этгээдээр хийлгэж баталгаажуулж байх зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийх аудитын багийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/141 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг аудитын нээлтийн уулзалтыг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хийж, завсрын аудитаар аудитын урьдчилсан үйл ажиллагаа, байгууллагын гадаад дотоод орчныг судлах, аудитын эрсдэлийг тодорхойлох, аудитын төлөвлөгөө боловсруулах, зарим эрсдэлтэй данстын түвшинд холбогдох горим сорил хэрэгжүүлсэн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Кэй Пи Эм Жи Аудит ХХК” гүйцэтгэсэн бөгөөд хугацаа хэтэрсэн хоног хүлээгдэж буй алдагдалд 1, үнэ цэний бууралтын бодлого журмын хэрэгжилтэд 1, СТОУС-18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга шинэ стандартыг бэлтгэх 1, нийт 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 5. Зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	100.0
Нийт дүн	3	-	3	-	100.0

*Эх сурвалж: Кэй Пи Эм Жи Аудит ХХК-иас Ди Би Эм лизинг ХХК-д 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн Удирдлагын захидал, Ди Би Эм лизинг ХХК-ийн зөвлөмжийн хэрэгжилт*

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн олон улсын стандарт, холбогдох дүрэм журамд нийцсэн байдал;
- Эрсдэлийн сангийн тооцоолол;

- Хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой асуудлыг авч үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,253.0 сая төгрөгийн 9 алдаа<sup>3</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлд кассын 0.03 сая төгрөгийн зарлагын гүйлгээг бүртгээгүй, нярвын тайлангийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Шүүхийн шийдвэрээр хүчингүй түрээсийн үндсэн төлбөр, хүү, алдангийн нийт 6,833.4 сая төгрөгийн авлагыг зардлаар хүлээн зөвшөөрсөн /Хаан шоргоолж ХХК 5,086.5 сая төгрөг, Алтайн хязгаар ХХК 1,746.9 сая төгрөг/;
- Санхүүгийн түрээсийн 3,240.1 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтыг орлогоор хүлээн зөвшөөрсөн;
- Тайлант хугацаанд 21.6 сая төгрөгийн хүлээн авсан үндсэн хөрөнгө болон 8.3 сая төгрөгийн төлбөр хийгдээгүй ажил үйлчилгээг худалдан авах гэрээний дүнгээр тус тус урьдчилж төлсөн тооцоо дансанд тусгасан;
- Галын аюулгүй байдлын самбар, галын хор зэрэг 1.7 сая төгрөгийн хангамжийн материалыг зардлаар шууд бүртгэсэн;
- Түрээсээр эзэмшүүлж байсан найдваргүй болсон хөрөнгийг хураан авч, түүний хадгалалт, хамгаалалтын зардалд зарцуулсан 30.2 сая төгрөгийг түрээслэгчээс авах авлагаар бүртгэлгүйгээр зардалд шууд тусгасан;
- Аудитын үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хийгдээгүй байхад 100.0 сая төгрөгийн аудитын төлбөрийн өглөг үүсгэж, зардалд бүртгэсэн;
- Тайлант онд 18 ажилтны чөлөөтэй, албан томилолттой байсан хугацаанд хоол, унааны 0.8 сая төгрөгийн хөнгөлөлтийг илүү тооцож олгосон;
- Жамьян Пайтан ХХК-д санхүүгийн түрээсээр олгосон 11 том оврын ачааны машины Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах зогсоолын 2023-2024 оны төлбөр болох 16.8 сая төгрөгийг зардлаар бүртгэсэн.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалт, НББОУС 1, СТОУС 9 стандартуудын заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, ангилал, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, тасалбар болголт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 16,905.8 сая төгрөгийн зөрчил<sup>4</sup> илэрсэнд, 12.5 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 16,878.4 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 14.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 16,905.8 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 16,760.0 сая төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1.** Компанийн нэр бүхий 2 ажилтанд гадаад албан томилолтоор БНСУ-д ажиллахад "Бусад зардал" нэрээр тус бүр 1,000.00 ам.доллар төсөвлөж, 6.9 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх",

<sup>3</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан 6.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**5.1.2.** Тайлант онд давхардсан тоогоор 29 ажилтанд ажилласан хугацааны нэмэгдлийг тооцож олгохдоо сар бүрийн бодогдсон үндсэн цалингаас бус тушаалаар тогтоосон үндсэн цалингаас тооцож нийт 3.6 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-т "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах", 43 дугаар зүйлийн 43.2.1-д "гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар "Журам батлах тухай" тушаалын хавсралтын 1.4.1-д "үндсэн цалин" гэж ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэсний төлөө ажил олгогчоос ажилтанд олгох хөлсийг хэлнэ. Үндсэн цалинд хийснээр болон цагаар тооцсон цалин, албан тушаалын цалин, хөдөлмөрийн гэрээгээр тусгайлан тохирсон цалин, тэдгээртэй адилтгах хэлбэрээр тогтоосон бусад хөлс гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилласан хугацааны нэмэгдлийг илүү олгосон 3.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**5.1.3.** 2025 онд чөлөөтэй, албан томилолттой байсан нэр бүхий 8 ажилтанд хоол, унааны нэмэгдлийг 0.2 сая төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/26 дугаар "Цалин хөлсний журам шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтын 5.3.1-т "Хоол, унааны хөнгөлөлтийг ажилласан хоногоор тооцох бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд Гүйцэтгэх захирлын тушаалаар хэмжээг тогтоож олгоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Чөлөөтэй, албан томилолттой байсан 8 ажилтанд хоол, унааны нэмэгдлийг илүү олгосон 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**5.1.4.** Гүйцэтгэх захирлын 2025 оны Б/65 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтантай ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс 1.5 сая төгрөг, 2025 оны А/24 дүгээр тушаалаар ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралт биеэр эдлээгүй ажилтнуудын тухайн хугацаанд ногдох ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний олговор олгохдоо ажилтанд 1 хоногийн илүү олговор 0.2 сая төгрөгийг тус тус илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 "Ажилтан ажил үүргийг нь гүйцэтгүүлэх зорилгоор олгосон аливаа ажлын багаж, төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хөрөнгө, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичиг, биет болон цахим мэдээлэл, холбогдох бусад зүйлийг нэг бүрчлэн ажил олгогчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны

А/191 дүгээр "Журам батлах тухай" тушаалын хавсралтын 3.4 "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно", Ди Би Эм Лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/19 дүгээр "Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаалын хавсралтын 4.2.12 "Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, цуцлагдсан тохиолдолд ашиглаж байсан эд хөрөнгө, баримт материал, цахим файл зэргийг Компанид хүлээлгэн өгч, зохих журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусгах," 10.10 "Ажлаас чөлөөлөгдсөн ажилтан сүүлийн тайлан дурдсанаас хойш хийсэн ажлын тайланг гаргах, хариуцсан ажил үүрэг, ажлын үнэмлэх, албан хэрэгцээнд ашиглаж байсан эд зүйлийг холбогдох ажилтанд хүлээлгэн өгөх, тойрох хуудсыг зуруулж, ажил хүлээлцсэн актыг үйлдэнэ" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтантай ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс ээлжийн амралтын олговорт илүү олгосон нийт 1.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

## 5.2 Албан шаардлага

**5.2.1.** Тайлант онд 18 санхүүгийн түрээсийн үндсэн болон хүү, алдангийн төлбөрийн 40,995.8 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 5 түрээсийн 16,878.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д "Нягтлан бодогчийн нэг орон тоотой аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа нягтлан бодогч, эсхүл гэрээт нягтлан бодогч нь ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүртгэлтэй 5 санхүүгийн түрээсийн 16,878.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 12.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч шууд зардалд бүртгэсэн, ашиглалтад байгаа хангамжийн материалыг зардалд тусгасан, мөн бараа материалын тайланг нэр төрлөөр бэлтгээгүй, жилийн эцэст тооллого хийгээгүй байна.

Энэ нь НББОУС 1.15-д Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг Үзэл баримтлал 3-д заасан хөрөнгө өр төлбөр, орлого зарлагын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг зориулалт, ашиглалтын хугацаа, шинж чанарыг нь үндэслэн зохих дансанд бүртгэн бараа материалын хөдөлгөөнийг иж бүрэн бүртгэх, бараа материалын үлдэгдэлд тооллого хийж, тооцоог бодож байх.

### 2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд 2.4 сая төгрөгийн мауз, зөөврийн хард, вирусийн программ, веб сайт зэрэг хангамжийн материал бүртгэлтэй, үндсэн хөрөнгө эзэмшигчийн карт, бүртгэл хөтөлж, хөдөлгөөн хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн

хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн шалгуур хангахгүй эд зүйлсийг хангамжийн материалын дансанд зөв ангилан бүртгэж, үндсэн хөрөнгө эзэмшигчийн карт, бүртгэлийг хөтөлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нягтлан бодох бүртгэлд кассын 0.03 сая төгрөгийн зарлагын гүйлгээг бүртгээгүй, нярвын тайлангийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	30.5	1	30.5			1	30.5				
Шүүхийн шийдвэрээр хүчингүй түрээсийн үндсэн төлбөр, хүү, алдангийн нийт 6,833.4 сая төгрөгийн авлагыг зардлаар хүлээн зөвшөөрсөн /Хаан шоргоолж ХХК 5,086.5 сая төгрөг, Алтайн хязгаар ХХК 1,746.9 сая төгрөг/	1	6,833,447.9			1	6,833,447.9	1	6,833,447.9				
Санхүүгийн түрээсийн 3,240.1 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтыг орлогоор хүлээн зөвшөөрсөн	1	3,240,077.0			1	3,240,077.0	1	3,240,077.0				
Тайлант хугацаанд 21.6 сая төгрөгийн хүлээн авсан үндсэн хөрөнгө болон 8.3 сая төгрөгийн төлбөр хийгдээгүй ажил үйлчилгээг худалдан авах гэрээний дүнгээр тус тус урьдчилж төлсөн тооцоо дансанд тусгасан	1	29,910.0			1	29,910.0	1	29,910.0				
Галын аюулгүй байдлын самбар, галын хор зэрэг 1.7 сая төгрөгийн хангамжийн материалыг зардлаар шууд бүртгэсэн	1	1,700.0			1	1,700.0	1	1,700.0				
Түрээсээр эзэмшүүлж байсан найдваргүй болсон хөрөнгийг хураан авч, түүний хадгалалт, хамгаалалтын зардалд зарцуулсан 30.2 сая төгрөгийг түрээслэгчээс авах авлагаар бүртгэлгүйгээр зардалд шууд тусгасан	1	30,195.0			1	30,195.0	1	30,195.0				
Аудитын үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хийгдээгүй байхад 100.0 сая төгрөгийн аудитын төлбөрийн өглөг үүсгэж, зардалд бүртгэсэн	1	100,000.0			1	100,000.0	1	100,000.0				
Тайлант онд 18 ажилтны чөлөөтэй, албан томилоттой байсан хугацаанд хоол, унааны 0.8 сая төгрөгийн хөнгөлөлтийг илүү тооцож олгосон	1	841.8			1	841.8	1	841.8				

Жамьян Пайтан ХХК-д санхүүгийн түрээсээр олгосон 11 том оврын ачааны машины Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах зогсоолын 2023-2024 оны төлбөр болох 16.8 сая төгрөгийг зардлаар бүртгэсэн.	1	16,775.0			1	16,775.0	1	16,775.0				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>10,252,977.2</b>	<b>1</b>	<b>30.5</b>	<b>8</b>	<b>10,252,946.7</b>	<b>9</b>	<b>10,252,977.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Компанийн нэр бүхий 2 ажилтанд гадаад албан томилолтоор БНСУ-д ажиллахад "Бусад зардал" нэрээр тус бүр 1,000.00 ам.доллар төсөвлөж, 6.9 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.	1	6,907.3	1	6,907.3								
Тайлант онд давхардсан тоогоор 29 ажилтанд ажилласан хугацааны нэмэгдлийг тооцож олгохдоо сар бүрийн бодогдсон үндсэн цалингаас бус тушаалаар тогтоосон үндсэн цалингаас тооцож нийт 3.6 сая төгрөгийг илүү олгосон байна.	1	3,651.8	1	3,651.8								
2025 оны 1-12 дугаар сард чөлөөтэй, албан томилолттой байсан нэр бүхий 8 ажилтанд хоол, унааны нэмэгдлийг 0.2 сая төгрөгөөр илүү олгосон байна.	1	245.1	1	245.1								
Гүйцэтгэх захирлын 2025 оны Б/65 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтантай ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс 1.5 сая төгрөг, 2025 оны А/24 дүгээр	1	1,712.1	1	1,712.1								

тушаалаар ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралт биеэр эдлээгүй ажилтнуудын тухайн хугацаанд ногдох ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний олговор олгохдоо ажилтанд 1 хоногийн илүү олговор 0.2 сая төгрөгийг тус тус илүү олгосон байна.												
Тайлант онд 18 санхүүгийн түрээсийн үндсэн болон хүү, алдангийн төлбөрийн 40,995.8 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 5 түрээсийн 16,878.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	16,878,454.8			1	16,878,454.8						
Тайлант онд 12.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч шууд зардалд бүртгэсэн, ашиглалтад байгаа хангамжийн материалыг зардалд тусгасан, мөн бараа материалын тайланг нэр төрлөөр бэлтгээгүй, жилийн эцэст тооллого хийгээгүй байна.	1	12,476.6					1	12,476.6				
Үндсэн хөрөнгийн дансанд 2.4 сая төгрөгийн мауз, зөөврийн хард, вирусийн программ, веб сайт зэрэг хангамжийн материал бүртгэлтэй, үндсэн хөрөнгө эзэмшигчийн карт, бүртгэл хөтөлж, хөдөлгөөн хийгээгүй байна.	1	2,403.5					1	2,403.5				
Байгууллагын цахим хуудсанд ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлын ажлын байранд тавигдах шаардлага, Гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, компанийн 2025 онд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, ЭМДШ, НДШ-ийн	1	-					1	-				

мэдээллийг тус тус байршуулаагүй байна.												
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>16,905,851.2</b>	<b>4</b>	<b>12,516.3</b>	<b>1</b>	<b>16,878,454.8</b>	<b>3</b>	<b>14,880.1</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 119 гүйлгээнээс 3,643.9 сая төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож, 19,737.0 сая төгрөгийн 111 мэдээллийг мэдээлээгүй, зарлагын нийт 14 гүйлгээнээс 42.8 сая төгрөгийн 5 мэдээллийг мэдээлээгүй, 212.7 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг ил тодоор мэдээлэх нийт 219.5 сая төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй, мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 3 шийдвэрийг нийтэд ил тод мэдээлээгүй байна.	1	23,855,910.2	1	23,855,910.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>23,855,910.2</b>	<b>1</b>	<b>23,855,910.2</b>		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 968/АД210205

Улаанбаатар хот

САГ - 2026/108/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 119 гүйлгээнээс 3,643,913,046.88 /гурван тэрбум зургаан зуун дөчин гурван сая есөн зуун арван гурван мянга дөчин зургаан төгрөг наян найман мөнгө/ төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож, 19,736,958,485.22 /арван есөн тэрбум долоон зуун гучин зургаан сая есөн зуун тавин найман мянга дөрвөн зуун наян таван төгрөг хорин хоёр мөнгө/ төгрөгийн 111 мэдээллийг мэдээлээгүй, зарлагын нийт 14 гүйлгээнээс 42,818,108.00 /дөчин хоёр сая найман зуун арван найман мянга нэг зуун найман/ төгрөгийн 5 мэдээллийг мэдээлээгүй, 212,725,600.00 /хоёр зуун арван хоёр сая долоон зуун хорин таван мянга зургаан зуун/ төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг ил тодоор мэдээлэх нийт 219,495,000.00 /хоёр зуун арван есөн сая дөрвөн зуун ерэн таван мянган/ төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй, мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 3 шийдвэрийг нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-т “5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном, нягтлан бодогч З.Авирмэд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.САРУУЛ  
Д.ЗЭНДМЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 969/АД160293

Улаанбаатар хот

САГ - 2026/108/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 5 санхүүгийн түрээсийн 16,878,454,826.60 (арван зургаан тэрбум найман зуун далан найман сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга найман зуун хорин зургаан төгрөг жаран мөнгө) төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Нягтлан бодогчийн нэг орон тоотой аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа нягтлан бодогч, эсхүл гэрээт нягтлан бодогч нь ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэнэ,” 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Бүртгэлтэй 5 санхүүгийн түрээсийн 16,878,454,826.60 (арван зургаан тэрбум найман зуун далан найман сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга найман зуун хорин зургаан төгрөг жаран мөнгө) төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном, нягтлан бодогч З.Авирмэд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.САРУУЛ  
Ч.АРИУНАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 190/АД160293

Улаанбаатар хот

САГ-2026/108/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд давхардсан тоогоор 29 ажилтанд ажилласан хугацааны нэмэгдлийг тооцож олгоходоо сар бүрийн бодогдсон үндсэн цалингаас бус тушаалаар тогтоосон үндсэн цалингаас тооцож нийт 3,651,834.58 (гурван сая зургаан зуун тавин нэгэн мянга найман зуун гучин дөрвөн төгрөг тавин найман мөнгө) төгрөгийг илүү олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-т “гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах”, 43 дугаар зүйлийн 43.2.1-д “гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар “Журам батлах тухай” тушаалын хавсралтын 1.4.1 “үндсэн цалин” гэж ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэсний төлөө ажил олгогчоос ажилтанд олгох хөлсийг хэлнэ. Үндсэн цалинд хийснээр болон цагаар тооцсон цалин, албан тушаалын цалин, хөдөлмөрийн гэрээгээр тусгайлан тохирсон цалин, тэдгээртэй адилтгах хэлбэрээр тогтоосон бусад хөлс” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Ажилласан хугацааны нэмэгдлийг илүү олгосон 3,651,834.58 (гурван сая зургаан зуун тавин нэгэн мянга найман зуун гучин дөрвөн төгрөг тавин найман мөнгө) төгрөгийг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном, нягтлан бодогч З.Авирмэд нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодномд хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.САРУУЛ  
Б.ЗОЛБАЯР  
Ч.АРИУНАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 191/A0160135

Улаанбаатар хот

САГ - 2026 /108/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн нэр бүхий 2 ажилтанд гадаад албан томилолтоор БНСУ-д ажиллахад "Бусад зардал" нэрээр тус бүр 1000 ам.доллар төсөвлөж, 6,907,340.00 (зургаан сая есөн зуун долоон мянга гурван зуун дөчин) төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Анхан шатны баримтгүй зарцуулсан 6,907,340.00 (зургаан сая есөн зуун долоон мянга гурван зуун дөчин) төгрөгийг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном, нягтлан бодогч З.Авирмэд нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном, нягтлан бодогч З.Авирмэд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ВАХИВАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.САРУУЛ  
Б.ӨЛЗИЙ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0325.SAG-R.Docx

1526200290



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 192/АД160293

Улаанбаатар хот

САГ-2026/108/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд чөлөөтэй, албан томилолттой байсан 8 ажилтанд хоол унааны нэмэгдлийг 245,100.00 (хоёр зуун дөчин таван мянга нэг зуун) төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Ди Би Эм Лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/26 дугаар "Цалин хөлсний журам шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтын 5.3.1 "Хоол, унааны хөнгөлөлтийг ажилласан хоногоор тооцох бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд Гүйцэтгэх захирлын тушаалаар хэмжээг тогтоож олгоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3 "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд:" 4.2.3.3 "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Чөлөөтэй, албан томилолттой байсан 8 ажилтанд хоол, унааны нэмэгдлийг илүү олгосон 245,100.00 (хоёр зуун дөчин таван мянга нэг зуун) төгрөгийг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном, нягтлан бодогч З.Авирмэд нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодномд хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.САРУУЛ  
Б.ЗОЛБАЯР  
Ч.АРИУНАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Акт\2026\0325\САГ-8.Docx

- 1526200294



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 193/АД160293

Улаанбаатар хот

САГ-2026/108/ИА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2025 оны Б/65 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтантай ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс 1,497,159.37 (нэг сая дөрвөн зуун ерэн долоон мянга нэг зуун тавин есөн төгрөг гучин долоон мөнгө) төгрөгийг, 2025 оны А/24 дүгээр тушаалаар ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралт биеэр эдлээгүй ажилтнуудын тухайн хугацаанд ногдох ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний олговор олгохдоо ажилтанд 1 хоногийн илүү олговор буюу 214,880.90 (хоёр зуун арван дөрвөн мянга найман зуун наян төгрөг ерөн мөнгө) төгрөгийг тус тус илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйцээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 "Ажилтан ажил үүргийг нь гүйцэтгүүлэх зорилгоор олгосон аливаа ажлын багаж, төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хөрөнгө, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичиг, биет болон цахим мэдээлэл, холбогдох бусад зүйлийг нэг бүрчлэн ажил олгогчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр "Журам батлах тухай" тушаалын хавсралтын 3.4 "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно", Ди Би Эм Лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/19 дүгээр "Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаалын хавсралтын 4.2.12 "Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, цуцлагдсан тохиолдолд ашиглаж байсан эд хөрөнгө, баримт материал, цахим файл зэргийг Компанид хүлээлгэн өгч, зохих журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусгах," 10.10 "Ажлаас чөлөөлөгдсөн ажилтан сүүлийн тайлан дурдсанаас хойш хийсэн ажлын тайланг гаргах, хариуцсан ажил үүрэг, ажлын үнэмлэх, албан хэрэгцээнд ашиглаж байсан эд зүйлийг холбогдох ажилтанд хүлээлгэн өгөх, тойрох хуудсыг зуруулж, ажил хүлээлцсэн актыг үйлдэнэ" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3 "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд:", 4.2.3.3 "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\AKI\2026\0325 SAG-8.Docx

1526200296

1. Ажлаас чөлөөлөгдсөн ажилтантай ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс илүү олгосон 1,497,159.37 (нэг сая дөрвөн зуун ерэн долоон мянга нэг зуун тавин есөн төгрөг гучин долоон мөнгө) төгрөг, ээлжийн амралтын олговорт илүү олгосон 214,880.90 (хоёр зуун арван дөрвөн мянга найман зуун наян төгрөг ерэн мөнгө) төгрөг, нийт 1,712,040.27 (нэг сая долоон зуун арван хоёр мянга дөчин төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном, нягтлан бодогч З.Авирмэд нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ди Би Эм лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодномд хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.САРУУЛ  
Б.ЗОЛБАЯР  
Ч.АРИУНАА





